

2020 оны 5-р сарын 15

**Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ( TSX: ERD | MSE: ERDN)**

**Компанийн танилцуулга**

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол улсын баруун урд хэсэгт хайгуул хийх эрх бүхий 3 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын тусгай зөвшөөрлүүд дээр хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонтогийн хөрөнгийн бирж (TSX:ERD) болон Монголын хөрөнгийн биржид (MSE:ERDN) давхар бүртгэлтэй.


Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн гурван ордыг нээн илрүүлсэн. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуула бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардагас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий ("Баян Хөндий" эсвэл "БХ"), Алтан Нар ("Алтан Нар" эсвэл "АН") ордууд юм. Мөн Баян Хөндий алтны төслөөс зүүн зүгт 40 км зайд Компани Зуун Мод хэмээх томоохон эс-молибденийн төслийг нээн илрүүлсэн ба энэхүү төслийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг 100% эзэмшдэг.

Компани 2019 оны 10 сарын 21-нд Tetra Tech Inc-ийн боловсруулсан NI 43-101 урьдчилсан ТЭЗҮ-ийн Техникийн Тайлангийн эерэг үр дүнг танилцуулсан бөгөөд энэхүү тайланд Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ, Алтан Нарын шинэчилсэн АШЭЭТ багтсан. Sustainability East Asia-аар ахлуулан, Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээг ("ESIA") 2020 оны эхний хагаст боловсруулж дуусна. Компани нь эцсийн ТЭЗҮ ("BFS"), анхны инженерчлал загвар ("FEED")-ын ажлуудыг 2019 оны 12 сараас боловсруулж эхэлсэн. 2021 оноос Компани нь алтны олборлолтыг эхлүүлэхээр төлөвлөж байгаа юм.

**Хөндий алтны дүүргийн нөөц ба тэлэх боломж**

**Баян Хөндийн Орд**

- Батлагдсан ба Магадцалсан нөөц: 3.7 г/т алтны агуулга бүхий 422,000 унц алт
- Баттай ба Бодитой нөөц: 3.16 г/т алтны агуулга бүхий 521,000 унц
- Боломжит нөөц: 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц
- Баруун урд бүсэд газрын дөт гүнд өндөр агуулга илрсэн
- Ил үрэхийн хязгаараас урагш болон хойш нөөцийг тэлэх боломжтой



**Алтан Нар - Баян Хөндийн хойд зүгт орших алт- полиметаллын нөөц**

Нөөц	Ангилал	Au унц (1.9)	Ag унц (10 г/т)	Pb фунт (0.6% г/т)	Zn фунт (0.6% г/т)
Алтан Нар 0.7 г/т AuEq захын агуулга	Бодит	318,000	2,350,000	63,800,000	69,520,000
	Боломжит	186,000	866,000	49,060,000	52,140,000

**Боломж:**

- Газрын дөт гүнд, өндөр агуулгатай хоёр алтны орд
- Хөндийн алтны төсөл нь БНХАУ-ын хилээс 200 км зайд оршдог
- Алтны нөөцийг тэлэх боломжтой, олон улсын дундаж агуулгаас гурав дахин өндөр алтны агуулга
- Өндөр өгөөж хүртэх боломжтой

**Эрсдэл:**

- Cash burn - Алт олборлолт төлөвлөснөөс хойшлогдвол үйл ажиллагаа явуулахад мөнгөний дутагдалд орох эрсдэл
- Эдийн засгууд эргэн сэргэснээр алтны ханш унах эрсдэл

**Шинжээчийн дүгнэлт**

Уул уурхайн хайгуулын компани нь олборлолт эхэлтэл олон жил алдагдалтай ажиллах тохиолдол цөөнгүй байдаг. Компани нь одоогоор ашиггүй ажиллаж байгаа хэдий ч сүүлийн 5 жилийн хугацаанд алдагдалаа жилд дунджаар 15.1 хувиар багасгасан. 2019 оны жилийн эцсийн байдлаар мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 5.1 сая кан.доллар богино хугацаат өр төлбөр 617,696 кан.доллар байсан байна. Үүнээс харахад компанийн quick ratio буюу төлбөр түргэн гүйцэтгэх чадвар 8.5 байгаа нь ойрын хугацаанд компани мөнгөний дутагдалд орох эрсдэл бага байгааг харуулж байна. Хэдийгээр үг эрсдэл бага байгаа ч олборлолтын шат уруу хурдацтай хөгжүүлж ашигт ажиллагааг эхлүүлэх шаардлагатай.

**Үнэлгээ**

Бид DCF тооцооллын аргыг ашиглан Баян Хөндий болон Алтан Нар ордуудын нөөц дээр тулгуурлан (Зуун Мод оруулаагүй) зорилтот үнийг **0.92** кан.доллар гэж тооцоов. Энэхүү ханш нь одоогийн ханшнаас 418 хувиар их байгаа тул хөрөнгө оруулахад тохиромжтой гэж үзэж байна.

**Санхүүгийн үзүүлэлтүүд**

**Үйл ажиллагааны зардлын тооцоолол**

	Баян Хөндий Урьдчилсан-ТЭЗҮ			Алтан Нар АШЭЭТ		
	LOM (сая ам.дол.)	ам.дол/унц	ам.дол/тонн	LOM (саяам.дол)	ам.дол/ унц AuEq	ам.дол/тонн
Уурхайн үйл ажиллагааны зардал	125	327	35	59	406	32
Боловсруулалтын зардал	113	295	32	56	388	31
Ерөнхий ба захиргааны зардал	15	40	5	8	60	5
Нийт үйл ажиллагааны зардал	253	662	72	123	854	68
АМНАТ болон бусад хураамжууд	30	77	8	11	77	6
Ашиглалтын үеийн хөрөнгө оруулалт болон уурхайн хаалтын зардал	2	7	1	-	-	-
Нийт зардал	285	746	81	134	931	74


	2015	2016	2017	2018	2019	CAGR
<b>Орлогын үр дүн</b>						
Үйл ажиллагааны зардал	2,241,194	3,615,786	4,118,970	3,716,065	2,706,510	4.83%
Цэвэр алдагдал	12,607,625	2,499,739	4,027,465	3,656,990	2,683,292	-32.08%
Нийт дэлгэрэнгүй алдагдал	11,653,721	2,794,184	4,286,037	3,717,848	3,686,195	-25.01%
<b>Баланс</b>						
Эргэлтийн хөрөнгө	748,631	1,147,806	3,420,750	1,896,294	5,246,253	62.70%
Эргэлтийн бус хөрөнгө	1,773,417	3,145,629	11,525,126	15,812,625	21,726,579	87.09%
Нийт хөрөнгө	2,522,048	4,293,435	14,945,876	17,708,919	26,972,832	80.84%
Нийт өр төлбөр	440,290	182,644	191,600	224,387	6,991,770	99.62%
Нийт эздийн өмч	2,081,758	4,110,791	14,754,276	17,484,532	19,981,062	76.01%
Нийт эздийн өмч ба өр төлбөр	2,522,048	4,293,435	14,945,876	17,708,919	26,972,832	80.84%
<b>Мөнгөн гүйлгээ</b>						
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(1,576,425)	(3,052,731)	(2,578,572)	(2,435,033)	(1,582,769)	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(888,847)	(571,174)	(8,598,667)	(4,328,278)	(6,778,269)	
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	3,004,238	4,019,324	13,331,232	5,286,358	11,719,652	
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	538,966	395,419	2,153,993	(1,476,953)	3,358,614	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	675,790	1,071,209	3,225,202	1,748,249	5,106,863	

**Компанийн мэдээлэл**

Хувьцааны код:	ERD	ERDN
Бирж:	TSX	MSE
Салбар:	Уул уурхай	Уул уурхай
Зах зээлийн үнэлгээ	41.23M CAD	2.04B MNT
Хаалтын ханш	0.215 CAD	470 MNT
Зорилтот үнэ:	0.92 CAD	1832.06 MNT
1 жилийн дээд/доод ханш	0.13-0.32 CAD	449.01-671.60 MNT
Арилжаалагдсан ширхэг	47,500	13,349
Арилжаалагдсан ширхэг (3 сар дундаж)	167,294	1,150
Бэглэ	1.44	-0.0089
Үнэ ашгийн харьцаа (P/E)	-	-
EPS	-	-
Нэгдөл ашгийн өгөөж	-0.09%	-0.09%
P/B харьцаа	2.06	2.06
Debt/Equity харьцаа	0.31	0.31
Дараагийн тайлант хугацаа	2020.05.14	2020.05.14
1 жилийн үзүүлэлт	10.26%	13.83%

**Гол хувьцаа эзэмшигчид**

- Жижиг хувьцаа эзэмшигчид
- Институцийн хөрөнгө оруулагчид
- Монгол хувьцаа эзэмшигчид
- Тек Ресурс
- ERD менежмент ба захирлууд



**1 жилийн хувьцааны ханш**

